



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн нийт 483,457,283.17 (дөрвөн зуун наян гурван сая дөрвөн зуун тавин долоон мянга хоёр зуун наян гурван төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 458,197,794.50 (дөрвөн зуун тавин найман сая нэг зуун ерэн долоон мянга долоон зуун ерэн дөрвөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

300407

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн
302 дугаар тогтоолын хавсралт

"ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг
1	Гагнуурын аппарат ВДУ-504	1978-01-01	ш	1	2,038,020.31	2,038,020.31	-
2	К-1 Нүүрс шидэгч	1961-01-01	ш	1	139,056,634.76	131,628,532.74	7,428,102.02
3	К-1 Шаталтын тавцан	1961-01-01	ш	1	342,362,628.10	324,531,241.45	17,831,386.65
					483,457,283.17	458,197,794.50	25,259,488.67
Нийт дүн					(дөрвөн зуун наян гурван сая дөрвөн зуун тавин долоон мянга хоёр зуун наян гурван төгрөг арван долоон мөнгө)	(дөрвөн зуун тавин найман сая нэг зуун ерэн долоон мянга долоон зуун ерэн дөрвөн төгрөг тавин мөнгө)	(хорин таван сая хоёр зуун тавин есөн мянга дөрвөн зуун наян найман төгрөг жаран долоон мөнгө)